

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайд
МУЗГ	Монголын уран зургийн галерей



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/624  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Монголын уран зургийн галерейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын уран зургийн галерейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Монголын уран зургийн галерей нь тайлант онд 4,963.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг байгууллагын дансаар дамжуулаагүй, цалин, урамшууллыг 2,040.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон, байгууллага, хувь хүнээс авах 13,911.1 мянган төгрөгийн авлагатай зэрэг алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшнээс хэтэрч, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Монголын уран зургийн галерейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Сарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, авлага, өглөг, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын уран зургийн галерейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 31-нээс 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди -Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын уран зургийн галерейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурлан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монголын уран зургийн уламжлал, дэг жаягийн давтагдашгүй онцлогийг шингээсэн орчин үеийн бүтээлийг олон улсад брэнджүүлж, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц



бүтээлч орчин бүрдүүлэх, түүхийн дурсгалт бүтээлүүдийн хадгалалт хамгаалалтыг олон улсын жишигт хүргэх”-д оршино.

Үйл ажиллагааны хэтийн зорилтууд:

1. Галерейн менежментийн чадавхыг бэхжүүлэх
  - a. Удирдлагын мэдээллийн системийг бий болгох
  - b. Хэрэглэгч төвт олон талт үйлчилгээг нэвтрүүлэх
  - c. Маркетингийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх
  - d. Менежментийн тогтолцоо бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах
2. Хөгжилд чиглэсэн нийгмийн түншлэлийг өргөжүүлэх
  - a. Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх
  - b. Дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх
  - c. Нийгмийн хөгжилд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэх
  - d. Дүрслэх урлаг судлалыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
3. Олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх
  - a. Галерейд шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангах
  - b. Дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх
  - c. Арт дилерийн тогтолцоог бүрдүүлэх
  - d. Соёлын үйлдвэрлэлийг дэмжсэн төслүүд хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (Шинэчилсэн найруулга);
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;
- ХХОАТ-ын тухай хууль (Шинэчилсэн найруулга);
- Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам.

## **МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ОНЦЛОХ АЖЛУУД**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын дарга Г.Эрдэнэбаттай байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-г үндэслэн 2019 оны 09 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 28-ны хооронд Зураасан зургийн сан хөмрөгийг засварлах, стандартын тавиур шүүгээгээр тоноглох ажлыг хийж гүйцэтгэж “Стандарт сан хөмрөг” төслийн ажлын хүрээнд Зураасан зургийн болон Уран сийлбэрийн сан хөмрөгийн өрөөг сэлгэн нүүлгэх ажлыг гүйцэтгэсэн байна.

**Монголын уран зургийн галерейн тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд:**

Монголын уран зургийн галерейн сан хөмрөгт хадгалагддаг, Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 227 тоот тушаалын дагуу дараах таван бүтээлийг Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалаар бүртгэсэн дараах 5 бүтээлийн хүрээ жаазыг шинэчлэн солих ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. О.Цэвэгжавын “Азарганы ноцолдоон” 1958 он;
2. Г.Одонгийн “Ажлын дараа” 1953-1954 он;
3. Н.Цүлтэмийн “Талын айл” 1955 он;
4. Б.Шаравын “Ленин” 1922 он;

## 5. Ү.Ядамсүрэнгийн “Өвгөн хуурч” 1955 он.

Эдгээр бүтээл нь Монголд европын уран зургийн арга ажиллагаа хөгжиж эхэлсэн үеийн шилдэг төлөөлөл болохын хувьд Дүрслэх урлагийн музейгээс Уран зургийн галерейд шилжин ирснээс хойш тасралтгүй 30 жил үзэсгэлэнгийн танхимд дэлгэгдэж ирсэн юм. Олон жилийн үйл ажиллагаа, зөөвөрлөлтийн улмаас анхны жааз нь хатаж сэнсрэх, гажиж холхих, эмтэрч хагарч, зүмбэр нь унах, өнгө зүс алдах зэргээр хадгалалт хамгаалалт болон үзэсгэлэнгийн шаардлага хангахгүй болсон нь бүтээлийн өнгө үзэмж төдийгүй тэдгээрийн үнэ цэнэд сөргөөр нөлөөлөх болсон юм. Иймд Түүх, соёлын дурсгалт өвийг хадгалан хамгаалах, өнгө үзэмжийг сайжруулах, насжилтыг уртасгах зорилгоор Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн есдүгээр бүлгийн 47.1.1, 47.1.2 дугаар заалт, Монголын уран зургийн галерейн захирлын А/04 тоот тушаал, Соёлын өвийн үндэсний төвийн 2019 оны 31 тоот албан бичиг, Түүх, соёлын хөдлөх үнэт зүйлийн улсын тооллогын салбар комиссын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Түүх, соёлын хосгүй үнэт таван бүтээлийн хүрээ жаазыг шинэчлэн солих ажлыг гүйцэтгэсэн байна.

Бүтээлүүдийг дэлхийн нэртэй галерейнуудын жишигт ойртуулан Итали улсад үйлдвэрлэсэн цэвэр модон материал бүхий өнгө үзэмж сайтай жаазаар, шинэчлэн солих ажлыг Уран зургийн галерей, Соёлын өвийн үндэсний төв, гүйцэтгэгч тал буюу DUBTSUN ХХК-ийн “New folder solutions” жаазны үйлдвэр зэрэг гурван байгууллага хамтран гүйцэтгэсэн болно. Ажлын явцад Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлагчид мэргэжлийн заавар зөвлөмжөөр ханган ажилласан бөгөөд захиалагч болон гүйцэтгэгч талууд өгсөн заавар зөвлөмжийг зохих түвшинд гүйцэтгэжээ.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Монголын уран зургийн галерейн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монголын уран зургийн галерей нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Монголын уран зургийн галерейн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Монголын уран зургийн галерейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 375,839.9 мянган төгрөгөөс тооцон 7,516.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар буюу 8,742.0 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин бага, ажил гүйлгээний тоо харьцангуй бага байгаатай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монголын уран зургийн галерейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,945.3 мянган төгрөгөөр буюу 0.29 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	14,279.5	13,911.1	(368.4)
Урьдчилгаа	22,464.4	-	(22,464.4)
Бараа материал	79,478.4	82,558.7	3,080.3
Үндсэн хөрөнгө	15,268,072.4	15,332,770.2	64,697.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,384,294.7</b>	<b>15,429,240.0</b>	<b>44,945.3</b>
Өр төлбөр	302.8	(4,652.4)	(4,955.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,383,991.9	15,433,892.4	49,900.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>15,384,294.7</b>	<b>15,429,240.0</b>	<b>44,945.3</b>

Авлага дансны үлдэгдэл 368.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудын авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 1998-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон хувь хүнээс авах 13,911.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 3,080.3 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд шинэ лого брендинг, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж оны эцэст Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос ирээдүйд үр өгөөжөө өгөх байгууллагын шинэ брендинг, бүтээгдэхүүн хөгжүүлэлттэй холбоотой бараа материалууд худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 2006 онд худалдаж авсан ашиглалтгүй удсан 2,137.5 мянган төгрөгийн 225 ширхэг “Монгол ахуй” ном байна. Энэ нь арт шоп-д борлуулахаар тавьсан боловч үйлчлүүлэгчид хэвлэгдсэн оноос шалтгаалан худалдан авдаггүй, хөдөлгөөнгүй бараа болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 64,697.8 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд өөрийн нэмэлт орлогын эх үүсвэрээр болон хандиваар, үнэ төлбөргүй хөрөнгө бэлтгэсэн зэргээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 35,589.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 46,482.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,433,892.4 мянган төгрөг болж 49,900.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн өсөлт байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар нь Монголын уран зургийн галерей нь тайлант онд төвлөрүүлэх орлого батлагдаагүй бөгөөд гүйцэтгэлээр 74,200.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалаар



баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих шинэчлэгдсэн журмын дагуу 73,227.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 347,537.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар баталж, 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 347,837.3 мянган төгрөг буюу 100.01 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын зардал болон бусад зардал хэтэрсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны байгууллагаас 23,959.7 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 74,200.5 мянган төгрөг буюу нийт 98,160,2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс цалингийн зардалд 20,500.0 мянга, нормативт зардалд 4,980.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 71,607.6 мянга, урсгал шилжүүлэгт 100.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 30,074.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6,663.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 23,410.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 6,663.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Байгууллагын захирлын 2019 оны А/59 тоот тушаалаар захирал өөртөө 1,700.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Зөрчил арилгах албан шаардлага өгөх,

2. Монголын уран зургийн галерейн нярвын 2015126092 тоот дансанд байгууллагын пос машины орлогын дансыг холбуулж тайлант хугацаанд 4,963.5 мянган төгрөгийн орлого орж, 4,774.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан, мөн "art shop"-ын уран бүтээлчдээс авч борлуулсан барааны орлогыг байгууллагын дансаар дамжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"; 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөх,

Аудитаар илэрсэн 23,410.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгч, Менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монголын уран зургийн галерейн Түүх соёлын дурсгалт зүйлсийн 2013 оны дахин үнэлгээний нэмэгдэл болох 14,314,724.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд хөрөнгө /бүтээл/ бүрээр биш нэг бөөн дүнгээр тусгасныг салган бүртгэх мөн Регистр програм (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн)-тай тулган шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Монголын уран зургийн галерей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 78 мэдээллийг хугацаанд нь, 60 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 359.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 5 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монголын уран зургийн галерейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 30,074.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тооцсон 8,742.0 мянган төгрөгийн материаллаг байдлын дүнгээс хэтэрч, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Монголын уран зургийн галерейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Балансын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1998-2015 онуудад үүссэн байгууллага, хувь хүнээс авах 13,911.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт зөрчигдөх, өр авлага төлөгдөхгүй байх.

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж өр, авлага үүсгэхгүй байх, он удаан жил болсон авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

1998-2009 оны хооронд ажиллаж байсан захиралтай холбоотой 5,139.0 мянган төгрөгийн дутагдлын хяналт шалгалтын актууд олдохгүй, мөн 1998 оноос өмнө ажиллаж байсан ажилтнуудтай холбоотой 952.2 мянган төгрөгийн авлагыг Д.Энхцэцэг дээр бүртгэсэн зэрэг шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 6,091.2 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь он удаан жил болсон, хариуцагч этгээд нь Монгол улсад оршин суухаа больсон /иргэний харьяаллаа өөрчилсөн/ зэрэг шалтгаануудтай холбоотой байна.

#### 2. Балансын данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харилцагч байгууллага, бэлтгэн нийлүүлэгч, хувь хүмүүсээс авах 4,980.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, хувь хүнд 327.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй илэрхийлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 2.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт зөрчигдөх.

**2.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж ажиллах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаас өгсөн зөвлөмжүүдийг мөрдлөг болгон холбогдох хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллана.

**3. Балансын данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бараа материалын дансанд түүвэр тооллого хийж үзэхэд үзвэрийн билет 3,862 ширхэг дутсан. Мөн уран зургийн катологиуд болон Мүзейн үзмэр цоморлигууд төрөл хоорондоо зөрсөн зөрчлүүд илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дүрдсэн хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

**3.2. Эрсдэл:**

Хөрөнгө шамшигдах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалт зөрчигдөх,

**3.3. Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтыг тус тус мөрдөж ажиллах,

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж Ресепшнийг 2020 оны эхнээс эд хариуцагчаар /нярваар/ бүртгэж, холбогдох хуулийг мөрдлөг болгон ажиллана.

**4. Балансын данстай холбоотой асуудал**

**4.1. Илрүүлэлт:**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Түүх соёл, музейн дурсгалт зүйлс дансанд бүртгэлтэй байгаа үзмэрүүдийг 2014 онд дахин үнэлсэн ба уг дахин үнэлгээг хөрөнгийн дансанд нэр төрлөөр нь бүртгэхдээ 21 гэсэн нэрээр “Дахин үнэлгээ” гэсэн хөрөнгө үүсгэн бөөн дүнгээр бүртгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дүрдсэн хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” гэсэн заалтууд, мөн дахин үнэлгээний үр дүнг бүртгэл тайланд тусгахдаа УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө стандартыг мөрдөөгүй байна.

**4.2. Эрсдэл:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт болон УСНББОУС17 Үндсэн хөрөнгө стандарт зөрчигдөх,

**4.3. Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2 дахь заалт болон УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө стандартыг мөрдөж ажиллах,

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу 2020 онд багтаан түүх соёл, музейн дурсгалт зүйлийн бүртгэлийн хөрөнгүүдийг 2014 оны дахин үнэлгээний баримттай тулгаж бөөн дүнгээр бүртгэсэн байдлыг залруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллана. 2018-2019 оны улсын үзлэг тооллогоор соёлын өвийн бүтээлийн дутагдал зөрүү илрээгүй болно.

#### **5. Балансын данстай холбоотой асуудал**

##### **5.1. Илрүүлэлт:**

Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн Регистер программд 3,413 ширхэг 15,073,161.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа бол санхүүгийн тайлангаар 3,366 ширхэг 15,249,905.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Санхүүгийн программын Түүх соёл, музейн дурсгалт зүйлс дансны бүртгэлийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн Регистер программын бүртгэлтэй тулган шалгах боломжгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

##### **5.2. Эрсдэл:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалт зөрчигдөх, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх,

##### **5.3. Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйл 67.1, 67.2, 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалтуудыг тус тус дагаж мөрдөж ажиллах,

##### **5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу 2020 онд багтаан түүх соёл, музейн дурсгалт зүйлийн бүртгэлийн хөрөнгүүдийг 2014 оны дахин үнэлгээний баримттай тулгаж бөөн дүнгээр бүртгэсэн байдлыг залруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллана. 2018-2019 оны улсын үзлэг тооллогоор соёлын өвийн бүтээлийн дутагдал зөрүү илрээгүй болно.

#### **6. Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой**

##### **6.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 146,363.5 мянган төгрөгийн 23 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг (1) жил, 2 ширхэг хөрөнгийн ашиглах хугацааг тавьж өгөөгүй ба ашиглах хугацаа тавигдаагүй хөрөнгөд 296.2 мянган төгрөгийн элэгдэл дутуу бодогдсон, өмнөх тайлант үед хамааралтай 1,270.8 мянган төгрөгийн элэгдлийг 2019 онд элэгдлийн зардлаар тусгасан нь БСШУСС-ын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон БСШУСС-ын 2017 оны А/40 тоот тушаал /Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам/-ын 2 дугаар хавсралтыг тус тус дагаж мөрдөөгүй байна.

##### **6.2. Эрсдэл:**

БСШУСС-ын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон БСШУСС-ын 2017 оны А/40 тоот тушаал /Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам/-ыг хэрэгжүүлэхгүй байх,

##### **6.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, БСШУСС-ын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон БСШУСС-ын 2017 оны А/40 тоот тушаал /Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам/-ын 2 дугаар хавсралт зэргийг мөрдөж ажиллах,

##### **6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу ашиглалтын жил зөрүүтэй орсон болон дутуу оруулсан хөрөнгүүдэд залруулга хийж оруулна.



## 7. Цалин хөлстэй холбоотой асуудал

### 7.1. Илрүүлэлт:

Ажиллагсдын цалинг олгоходоо ТҮСУ-ийн ангилал, шатлалыг баримтлаагүй байна. Тухайлбал:

а) Бүртгэл мэдээллийн санчийн цалинг захирлын 2019 оны А/06 дугаар тушаалаар ТҮСУ-4-3 шатлалаар 641,950 төгрөгөөр тогтоосон байхад цалинг 629,328 төгрөгөөр, архив бичиг хэргийн эрхлэгчийн цалинг ТҮ-5-1 шатлалын дагуу 521,214 төгрөгөөр тогтоосон байхад 486,242 төгрөгөөр тус тус олгож нийт 340,286 төгрөгийн цалин дутуу олгосон нь Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 8, 9 дүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 7.2. Эрсдэл:

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 8 болон 9 дүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг мөрдөхгүй байх,

### 7.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 8 болон 9 дүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт болон байгууллагын даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллах,

